

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/167/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2026 оны 02 дүгээр сарын 25

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер:

М.Алтантуяа

Утас: 70442424

Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор:

Б.Нарангэрэл

Утас: 99009293

Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/64
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Шинэжинст сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 569,392.4 мянган төгрөгийн өртөг бүхий сургуулийн спорт заалны засварын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050190

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	356,480,316.37	429,037,378.99
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	269,904,234.17	302,653,778.01
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	269,904,234.17	302,653,778.01
3121	Төгрөг	269,904,234.17	302,653,778.01
31211	Төрийн сангийн харилцах	269,904,234.17	302,653,778.01
33	АВЛАГА	900,000.00	358,990.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	900,000.00	358,990.40
35	БАРАА МАТЕРИАЛ	85,676,082.20	126,024,610.58
351	Түүхий эд материал	27,857,686.00	27,857,686.00
35110	Тусгай зориулалттай материал	27,857,686.00	27,857,686.00
354	Хангамжийн материал	57,818,396.20	98,166,924.58
35410	Бичиг хэргийн материал	100,000.00	100,000.00
35420	Аж ахуйн материал	16,074,857.80	16,074,857.80
35440	Түлш, шатах тослох материал	00.40	00.40
35470	Бусад хангамжийн материал	41,643,538.00	81,992,066.38
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,301,350,855.17	1,869,073,894.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,301,350,855.17	1,869,073,894.88
392	Биет хөрөнгө	1,271,052,855.17	1,838,775,894.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,321,491,066.88	1,890,883,473.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-314,243,530.19	-364,454,009.63
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	463,685,804.86	495,616,425.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	-241,985,576.54	-320,359,533.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	107,538,976.00	216,980,776.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-80,868,479.84	-95,325,832.27
39217	Ном	15,434,594.00	15,434,594.00
393	Биет бус хөрөнгө	30,298,000.00	30,298,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,298,000.00	30,298,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,657,831,171.54	2,298,111,273.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,657,831,171.54	2,298,111,273.87
51	Засгийн газрын хувь оролцоо	1,657,831,171.54	2,298,111,273.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	770,683,652.01	770,683,652.01
51101	Өмч: - төрийн	770,683,652.01	770,683,652.01
512	Хуримтлагдсан үр дүн	97,530,146.38	737,810,248.71
51210	Өмнөх үеийн үр дүн	97,530,146.38	97,530,146.38
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	640,280,102.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	789,617,373.15	789,617,373.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,657,831,171.54	2,298,111,273.87

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,903,174,400.00	2,834,705,856.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,797,600.00	719,330,356.43
120	Нийтлэг татварын бус орлого	102,797,600.00	719,330,356.43
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	102,122,600.00	681,746,828.05
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал	00.00	37,248,528.38
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	675,000.00	335,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	675,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	335,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,800,376,800.00	2,115,375,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,636,339,300.00	1,839,570,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,636,339,300.00	1,839,570,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,037,500.00	275,805,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,037,500.00	275,805,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,759,808,597.43	2,194,425,754.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,759,808,597.43	2,194,425,754.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,671,780,884.43	2,086,858,056.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,143,567,345.85	1,456,322,496.71
210101	Үндсэн цалин	752,452,019.22	806,910,566.53
210102	Нэмэгдэл	334,155,806.63	550,037,144.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	19,256,000.00
210104	Урамшуулал	56,959,520.00	80,118,785.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,891,482.29	178,443,184.55
210201	Тэтгэврийн даатгал	98,929,938.73	112,807,684.55
210202	Тэтгэмжийн даатгал	11,557,577.57	16,408,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,717,401.48	8,204,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,997,796.50	8,204,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,688,768.01	32,817,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,453,682.00	193,309,251.00
210301	Гэрэл, цахилгаан	8,521,258.00	12,006,166.00
210302	Түлш, халаалт	138,932,424.00	180,983,085.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,524,939.57	13,770,942.00
210401	Бичиг хэрэг	2,943,200.00	2,010,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,334,489.57	359,334.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	340,000.00	505,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,907,250.00	10,896,608.00
2105	Нормативт зардал	52,276,350.00	54,862,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,616,650.00	390,200.00
210502	Хоол, хүнс	45,300,200.00	54,472,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,359,500.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,116,600.00	2,468,000.00
210604	Урсгал засвар	7,116,600.00	2,468,000.00
2107	Томилолт, зочны зардал	160,000.00	120,000.00
210702	Дотоод албан томилолт	160,000.00	120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,790,632.53	20,298,204.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,854,000.00	1,521,017.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,936,632.53	18,777,186.91
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,999,852.19	167,263,277.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,632,000.00	15,511,089.00

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,650,050.00	8,710,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,717,802.19	143,041,788.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,027,713.00	107,567,697.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,478,895.00	105,057,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,383,500.00	83,640,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,095,395.00	21,417,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,548,818.00	2,510,697.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,548,818.00	2,510,697.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	143,365,802.57	640,280,102.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	143,365,802.57	640,280,102.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,801,051,800.00	2,115,710,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	675,000.00	335,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	675,000.00	335,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	675,000.00	335,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	675,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	335,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,800,376,800.00	2,115,375,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,636,339,300.00	1,839,570,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,636,339,300.00	1,839,570,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,037,500.00	275,805,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,037,500.00	275,805,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,650,687,795.24	2,053,942,956.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,650,687,795.24	2,053,942,956.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,562,660,082.24	1,946,375,258.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,146,878,302.85	1,455,781,487.11
210101	Үндсэн цалин	725,100,793.23	776,121,247.04
210102	Нэмэгдэл	342,977,191.33	579,121,815.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	19,256,000.00
210104	Урамшуулал	78,800,318.29	81,282,424.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,480,525.29	178,443,184.55
210201	Тэтгэврийн даатгал	92,488,025.29	112,807,684.55
210202	Тэтгэмжийн даатгал	12,498,200.00	16,408,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,249,200.00	8,204,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,249,200.00	8,204,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,995,900.00	32,817,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,453,682.00	193,309,251.00
210301	Гэрэл, цахилгаан	8,521,258.00	12,006,166.00
210302	Түлш, халаалт	138,932,424.00	180,983,085.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	320,000.00

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	45,300,200.00	54,472,500.00
210502	Хоол, хүнс	45,300,200.00	54,472,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,035,000.00	779,500.00
210604	Урсгал засвар	7,035,000.00	779,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,271,632.53	21,976,204.87
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,271,632.53	21,976,204.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,240,739.57	41,613,131.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,925,689.57	32,662,731.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,315,050.00	8,950,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,027,713.00	107,567,697.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,478,895.00	105,057,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,383,500.00	83,640,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,095,395.00	21,417,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,548,818.00	2,510,697.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,548,818.00	2,510,697.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>150,364,004.76</u>	<u>61,767,543.84</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,930,000.00	29,018,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,930,000.00	29,018,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,930,000.00	29,018,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,930,000.00	29,018,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-9,930,000.00</u>	<u>-29,018,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	140,434,004.76	32,749,543.84
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	129,470,229.41	269,904,234.17
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	269,904,234.17	302,653,778.01

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	770,683,652.01	902,514,882.82	-3,801,892.55	1,669,396,642.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	770,683,652.01	902,514,882.82	-3,801,892.55	1,669,396,642.28
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,133,565.79	-25,133,565.79
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	770,683,652.01	789,617,373.15	97,530,146.38	1,657,831,171.54
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	770,683,652.01	789,617,373.15	97,530,146.38	1,657,831,171.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	770,683,652.01	789,617,373.15	97,530,146.38	1,657,831,171.54
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	640,280,102.33	640,280,102.33
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	770,683,652.01	789,617,373.15	737,810,248.71	2,298,111,273.87

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,119,778,100.00	1,839,570,300.00	280,207,800.00	86.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,119,778,100.00	1,839,570,300.00	280,207,800.00	86.8
Улсын төсвөөс санхүүжих	2,119,778,100.00	1,839,570,300.00	280,207,800.00	86.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	335,000.00	(335,000.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	335,000.00	(335,000.00)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,119,778,100.00	1,807,155,756.16	312,622,343.84	85.3
УРСГАЛ ЗАРДАЛ	2,119,778,100.00	1,807,155,756.16	312,622,343.84	85.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,008,799,500.00	1,702,098,756.16	306,700,743.84	84.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,636,911,300.00	1,385,157,641.68	251,753,658.32	84.6
Үндсэн цалин	960,126,400.00	776,121,247.04	184,005,152.96	80.8
Нэмэгдэл	603,866,000.00	508,497,970.22	95,368,029.78	84.2
Унаа хоолны хөнгөлөлт	-	19,256,000.00	(19,256,000.00)	
Урамшуулал	72,918,900.00	81,282,424.42	(8,363,524.42)	111.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204,613,800.00	169,861,278.61	34,752,521.39	83.0
Тэтгэврийн даатгал	139,137,500.00	107,107,778.61	32,029,721.39	77.0
Тэтгэмжийн даатгал	16,369,100.00	15,688,400.00	680,700.00	95.8
ҮОМШӨ-ний даатгал	8,184,500.00	7,844,400.00	340,100.00	95.8
Ажилгүйдлийн даатгал	8,184,500.00	7,844,400.00	340,100.00	95.8
Эрүүл мэндийн даатгал	32,738,200.00	31,376,300.00	1,361,900.00	95.8
Нормативт зардал	60,004,100.00	54,472,500.00	5,531,600.00	90.8
Хоол, хүнс	60,004,100.00	54,472,500.00	5,531,600.00	90.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,071,300.00	21,976,204.87	8,095,095.13	73.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,071,300.00	21,976,204.87	8,095,095.13	73.1
Бараа үйлчилгээний бусад зардал	77,199,000.00	70,631,131.00	6,567,869.00	91.5
Бараа үйлчилгээний бусад зардал	68,166,100.00	61,680,731.00	6,485,369.00	90.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,032,900.00	8,950,400.00	82,500.00	99.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,978,600.00	105,057,000.00	5,921,600.00	94.7
Бусад урсгал шилжүүлэг	110,978,600.00	105,057,000.00	5,921,600.00	94.7
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	89,561,600.00	83,640,000.00	5,921,600.00	93.4
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	21,417,000.00	21,417,000.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	269,904,234.17		86.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	302,653,778.01		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	275,805,200.00	273,294,502.37	2,510,697.63	99.09
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	275,805,200.00	273,294,502.37	2,510,697.63	99.09
Орон нутгийн төсвөөс	275,805,200.00	273,294,502.37	2,510,697.63	99.09
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	255,751,300.00	249,340,751.00	6,410,549.00	97.49
УРСГАЛ ЗАРДАЛ	255,751,300.00	249,340,751.00	6,410,549.00	97.49
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,805,200.00	273,294,502.37	2,510,697.63	99.09
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,051,600.00	70,623,845.43	1,427,754.57	98.02
Нэмэгдэл	72,051,600.00	70,623,845.43	1,427,754.57	98.02
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,006,400.00	8,581,905.94	424,494.06	95.29
Тэтгэврийн даатгал	6,124,400.00	5,699,905.94	424,494.06	93.07
Тэтгэмжийн даатгал	720,400.00	720,400.00	-	100.00
ҮОМШӨ-ний даатгал	360,300.00	360,300.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	360,300.00	360,300.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	1,441,000.00	1,441,000.00	-	100.00

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	194,747,200.00	194,088,751.00	658,449.00	99.66
Гэрэл, цахилгаан	12,264,100.00	12,006,166.00	257,934.00	97.90
Түлш, халаалт	180,983,100.00	180,983,085.00	15.00	100.00
Цэвэр, бохир ус	500,000.00	320,000.00	180,000.00	64.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	779,500.00	220,500.00	77.95
Урсгал засвар	1,000,000.00	779,500.00	220,500.00	77.95

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Суралцагч бүрийн тэгш оролцоог ханган ээлжит хичээлийн чанарыг сайжруулах замаар тэдний суурь болон ерөнхий чадамж, төлөвшилд бодит ахиц гаргана” гэсэн зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Боловсролын ерөнхий газрын дотоод аудитаас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 640,280.1 мянган төгрөг буюу 38.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	356,480.3	21.5%	429,037.4	18.7%	72,557.1	20.4%
Мөнгөн хөрөнгө	269,904.2	16.3%	302,653.8	13.2%	32,749.5	12.1%
Авлага	900.0	0.1%	359.0	0.0%	(541.0)	-60.1%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	85,676.1	5.2%	126,024.6	5.5%	40,348.5	47.1%
ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	1,301,350.9	78.5%	1,869,073.9	81.3%	567,723.0	43.6%
Үндсэн хөрөнгө	1,938,748.4	116.9%	2,649,513.3	115.3%	710,764.8	36.7%
Хуримтлагдсан элэгдэл	(637,397.6)	-38.4%	(780,439.4)	-34.0%	(143,041.8)	22.4%
Нийт хөрөнгө	1,657,831.2	100.0%	2,298,111.3	100.0%	640,280.1	38.6%
Өр төлбөр	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,657,831.2	100.0%	2,298,111.3	100.0%	640,280.1	38.6%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,657,831.2	100.0%	2,298,111.3	100.0%	640,280.1	38.6%

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 426,874.9 мянган төгрөг байгаа нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 359.0 мянга буюу 541.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ажилчидтай холбоотой 900.0 мянган төгрөгийн авлагыг тайлант онд суутган тооцсон бөгөөд 2025 онд ХХОАТ-ын илүү төлөлт болох 359.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 126,024.6 мянган төгрөг болж 40,348.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 168,163.7 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 37,248.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 165,063.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,649,513.3 мянган төгрөг болж 710,764.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 29,018.0 мянга, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 70,560.0 мянган төгрөгийн өртөг бүхий тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, мөн Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар 17,500.2 мянган төгрөгийн өртөг бүхий компьютер, тавилга эд хогшил, бусад байгууллагаас 24,294.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил,

Шинэжинст сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 569,392.4 мянган төгрөгийн өртөг бүхий спорт заалны засварын ажлыг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,298,111.3 мянган төгрөг болж 640,280.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 640,280.1 мянган төгрөгтэй холбоотой байна.

Тайлант онд тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ны 300.0 мянган төгрөгийн өртөг бүхий Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд тайлант онд лицензийн төлбөрт 473.0 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,495,639.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,495,639.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 409,992.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,905,631.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 2,119,778.1 мянган төгрөгийн төсөв баталсан бөгөөд гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,839,570.3 мянга, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоор 335.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,807,155.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,807,155.8 мянган төгрөг буюу 85.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 251,753.7 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 34,752.5 мянга, нормативд зардал 5,531.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 8,095.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 6,567.9 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 5,921.6 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт, %
1	71802 Ерөнхий боловсрол	2,119,778.1	1,807,155.8	312,622.3	85.3
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	2,473.6	2,431.1	42.5	98.3
2	80233 Хүүхэд хамгаалал	3,574.9	2,415.0	1,159.9	67.6
3	80312 Сургалт семинар	2,339.2	2,330.0	9.2	99.6
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	3,453.9	2,250.0	1,203.9	65.1
5	81801 Үдийн цай хөтөлбөр	89,561.6	83,640.0	5,921.6	93.4
6	81806 Дотуур байрны үйлчилгээ	266,799.9	224,147.2	42,652.7	84.0
7	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	20,596.0	20,586.0	10.0	100.0
8	81823 Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	8,667.5	5,785.8	2,881.8	66.8
9	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	20,924.0	16,286.4	4,637.6	77.8
10	81834 Боловсролын стандарт, сургалт	1,580,358.4	1,346,490.1	233,868.3	85.2
11	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	107,357.0	94,163.2	13,193.8	87.7
12	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	175.0	0.0	175.0	0.0
13	81875 Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	13,497.1	6,631.0	6,866.1	49.1

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 275,805.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 275,805.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 194,088.8 мянган төгрөг, цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 79,205.8 мянган төгрөгийн зарцуулж, 2510.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

Бүтэц орон тоог Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар нийт 45 албан хаагчийн орон тоог баталсан бөгөөд гүйцэтгэлээр 45 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Цалингийн зардалд нийт 1,912,716.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,657,774.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагын цалингийн зардалд хоолны хөнгөлөлтийг батлаагүй бөгөөд Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/06 дугаар тушаалыг үндэслэн нэг хүний 8.0 мянган төгрөгөөр тооцож нийт 19,256.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг олгосон байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд тус байгууллагад төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 189,152.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төрлийн бараа, ажил үйлчилгээний тендерийг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тус байгууллага нь 108,713.7 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий үдийн хоолны хүнсний материал нийлүүлэх тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 80,438.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий дотуур байрны хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх тендерийг харьцуулалтын аргаар зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан нийт 2.2 мянган төгрөгийн тендерийн хэмнэлтийг бий болгосон байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Дд	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр	Төрөл	Төсөвт өртөг	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам, арга	Шалгарсан ААНБ	Гэрээний үнэ
1	Дотуур байрны хүүхдийн хоол хүнсний материал	Бараа	80,438.4	Харьцуулалтын арга	Цагаан сарлаг ХХК	80,436.6
2	Үдийн хоолны хүнсний материал нийлүүлэх	Бараа	108,713.7	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	Цагаан сарлаг ХХК	108,713.3
	Дүн		189,152.1			189,149.9

Эх сурвалж: Tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Г.Долгор, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Х.Гантулга нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан

нийт төсөвт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөвт зардал 2,119,778.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 21,197.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг, төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 13,778.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 437.9 мянга төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

Байгууллагын даргын 2025 оны А/09 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгууллагын ёс зүйн дэд хороо байгуулан нарийн бичгийн даргад цалингийн зардлаас 2,222.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.2."Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 10.2."Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомжийг зөрчиж илүү олгосон цалинг холбогдох буруутай албан тушаалтнуудаар буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоов.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 346,044.3 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 83,447.9 мянган төгрөгийн 7 гүйлгээ, худалдан авах ажиллагааны тайлан, дараа жилийн төсвийн /зорилтот түвшин/ төсөл,

Санхүүгийн тайлан /хагас жил тутамд/, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт мэдээлээгүй, хуулийн 6.1.1-д заасан "Байгууллагын батлагдсан төсөв", "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Тухайн жилийн төсөвт /зорилтот түвшинд/ орсон нэмэлт, өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой 16,238.5 мянган төгрөгийн 13 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.2.1, 6.4.5-д заасан мэдээллийг хугацаанд бүрэн байршуулж, түүнд хяналт тавьж байх зөвлөмжийг аймгийн Боловсролын газрын тайланд тусгахаар шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баян ташаагийн эх аудит ХХК-ын аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, аудитаар илэрсэн зөрчилд 1,157.6 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 995,728.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025.05.28-ны өдрийн 41 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	1,157.6	4	1,157.6	100
Албан шаардлага	2	995,728.4	2	995,728.4	100
Зөвлөмж					
Нийт дүн	6	996,886.0	6	996,886.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 678,300.2 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 858.0 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд илүү тусгасан байгаа УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, мөн Үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийг тулгахад 10 дугаар сард ажлаас чөлөөлөгдсөн нэг ажилтанд олгосон урьдчилгааг суутгаагүй байсныг байгууллагын дансанд буцаан тушаалгасан бөгөөд уг 700.0 мянган төгрөгийн цалинг санхүүгийн тайланд бүртгээгүй зөрүү үүсгэсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, Иж бүрэн байх, Үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3. Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 676,742.2 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсан гэсэн ангиллаар бүртгэсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, Ангилал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 291,765.9 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс 8,803.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 282,962.3 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 2 ажилтны 1,584.0 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын санд илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө", 32 дугаар зүйлийн 32.2.2 "Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын санд илүү мэдээлсэн зөрүүг тооцож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.2 Нөхөн хангалтын зардлаас 4,997.0 мянган төгрөгийн өртөг бүхий зарлан мэдээлэх тоног төхөөрөмжийг хэрэгцээ шаардлагад үндэслээгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсролын сайдын 2024 оны А/279 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 2.2.2.1 "Шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээнд үндэслэн байгууллагын түвшинд хэрэгцээг эрэмбэлж, төсвийн төвлөрүүлэн болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх", 2.2.2.4 "Батлагдсан жагсаалтын дагуу энэхүү журмын 2.2.2.2-т заасны дагуу худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулж, тайлагнах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх аргачлалыг баримтлан журамд заасны дагуу төлөвлөж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.3 Байгууллагын даргын 2025 оны А/09 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгууллагын ёс зүйн дэд хороо байгуулан нарийн бичгийн даргад цалингийн зардлаас 2,222.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.2."Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө", 10.2."Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомж зөрчиж ёс зүйн хорооны урамшуулал олгодог байдлыг таслан зогсоож, зөрчлийг арилган, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.4 Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2026 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын

байгууллагад ирүүлэхээр заасан байхад хуульд заасан хугацаанд ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх, хууль журмыг хэрэгжүүлж ажиллагаагүй Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн захиралд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах арга хэмжээ авч ажиллахыг Баянхонгор аймгийн Боловсролын газрын даргад хүргүүлж, биелэлтийг 2026 оны 02 дугаар сарын 27-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд 282,962.3 мянган төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхсөн 203 нэр төрлийн 1413 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглалтыг шаардлага хангасан хөрөнгийг дахин үнэлэх, ашиглалтын шаардлага хангаагүй хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр данс бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 858.0 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд илүү тусгасан	1	858.0			1	858.0	1	858.0		
Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийг тулгахад 10 дугаар сард ажлаас чөлөөлөгдсөн нэг ажилтанд олгосон урьдчилгааг суутгаагүй байсныг байгууллагын дансанд буцаан тушаалгасан бөгөөд уг 700.0 мянган төгрөгийн цалинг санхүүгийн тайланд бүртгээгүй зөрүү үүсгэсэн	1	700.0	1	700.0			1	700.0		
Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 676,742.2 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авсан гэсэн ангиллаар бүртгэсэн	1	676,742.2			1	676,742.2	1	676,742.2		
Дүн	3	678,300.2	1	700.0	2	677,600.2	3	678,300.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 2 ажилтны 1,584.0 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын санд илүү мэдээлсэн байна.	1	1,584.0			1	1,584.0				
Нөхөн хангалтын зардлаас 4,997.0 мянган төгрөгийн өртөг бүхий зарлан мэдээлэх тоног төхөөрөмжийг хэрэгцээ шаардлагад үндэслээгүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	4,997.0			1	4,997.0				
Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлээ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2026 оны 01 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр заасан байхад хуульд заасан хугацаанд ирүүлээгүй байна.	1	0							1	0
Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд 282,962.3 мянган төгрөгийн анхны өртөг бүхий элэгдлээрээ өртгөө нөхсөн 203 нэр төрлийн 1413 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	1	282,962.3					1	282,962.3		
Нийт дүн	4	289,543.3			2	6,581.0	1	282,962.3	1	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Байгууллагын даргын 2025 оны А/09 дүгээр тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгууллагын ёс зүйн дэд хороо байгуулан нарийн бичгийн даргад цалингийн зардлаас 2,222.6 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	2,222.6			1	2,222.6			
Дүн	1	2,222.6			1	2,222.6			

-----oOo-----